



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 406


Улаанбаатар
хот

Хөрөнгө гаргах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5.1, 11.5.4, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.18, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын хариу арга хэмжээг эрчимжүүлэх, "Омикрон" хувилбараас урьдчилан сэргийлэх, эм тариа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, олон улсын нислэгийн ачаа тээвэрт шаардагдах 2.0 (хоёр) тэрбум төгрөг, хилийн боомтуудаар импортын бараа татан авах, чингэлэг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд шаардагдах 6.6 (зургаан тэрбум зургаан зуун сая) тэрбум төгрөгийг тус тус тооцож Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрүүл мэндийн сайд С.Энхболдод тус тус үүрэг болгосугай.



Эрүүл мэндийн сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ЖАВХЛАН

С.ЭНХБОЛД